



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/172

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, МУИС-ийн Дүрмийн 4.3.8.4, Захиргааны зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1."МУИС-д судалгааны лаборатори ажиллуулах журам"-ыг хавсралтаар баталж, 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инноваци, гадаад харилцаа хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг), Хөгжил, санхүү хариуцсан дэд захирал (Ц.Болормаа), Ахисан түвшний сургуулийн бодлогын газрын дарга (Б.Энх-Амгалан) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар МУИС-д байгаль, нийгэм, хүмүүнлэг ба инженерийн шинжлэх ухааны салбарын судалгааны лабораторийг байгуулах, удирдлагын зохион байгуулалт, үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Лабораторийн үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, нэр томъёоны тодорхойлолт

1.2.1. Лабораторийн үндсэн зорилго нь Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инноваци, нийгэм-эдийн засгийн сорилтуудыг шинжлэх ухааны ололтыг ашиглан шийдвэрлэх, судалгаагаар дамжуулан үндэсний чадварлаг хүний нөөцийг бэлтгэхэд оршино.

1.2.2. “Судалгааны лаборатори” (цаашид лаборатори гэх) нь эрдэм шинжилгээ, инновацийн бүтцэд хамаарагдах шинжлэх ухааны тодорхой чиглэлээр хэмжилт, туршилт, судалгаа, үр дүнгийн боловсруулалтын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмж бүхий орчин бүрдсэн судалгааны байгууламжийн нэгж байна.

1.2.3 “Туршилт-боловсруулалтын лаборатори” нь эрдэм шинжилгээ, инновацийн бүтцэд хамаарагдах шинжлэх ухааны тодорхой чиглэлээр хэмжилт, туршилт, судалгаа, бүтээгдэхүүний бага оврын боловсруулалтын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмж бүхий орчин бүрдсэн судалгааны байгууламжийн нэгж байна.

1.3. Нийтлэг зарчим.

1.3.1. Лабораторийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх хөдөлмөрийн харилцаанд энэхүү журам үйлчлэхгүй бөгөөд “Монгол Улсын хөдөлмөрийн хууль”, “МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам”, “МУИС-д Эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам” ба бусад холбогдох журмаар зохицуулагдана.

1.3.2. Лаборатори нь эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааны хараат бус, санхүүжилтийн хувьд өөрийгөө санхүүжүүлэх зарчимд үндэслэнэ.

Лабораторийг санхүүжүүлэх зарчим нь түүнд оруулах МУИС-ийн санхүүгийн болон бусад дэмжлэгийг хязгаарлах үндэслэл болохгүй.

1.3.3. Лабораторийн үндсэн мэдээллийг МУИС-ийн Эрдэм шинжилгээ менежментийн мэдээллийн системд (ЭШММС) заавал бүртгүүлнэ.

1.3.4. Хувь хүн болон олон нийтэд онцгой аюултай ангиллын лабораторийг сургалтын зориулалттай байранд байршуулж үл болно.

## ХОЁР. ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. МУИС-д ажиллаж буй үндсэн орон тооны профессор, дэд профессор лаборатори байгуулах санал дэвшүүлэх эрхтэй.

2.2. Профессор, дэд профессор нь шинээр лаборатори байгуулах төслийг бүрэлдэхүүн сургуулийн салбарын Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн тохиолдолд Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс (ЭШИХ)-ээр хянуулан МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

2.3. Лаборатори байгуулах профессор, дэд профессор нь санал боловсруулахдаа дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэл болгоно. Үүнд:

2.3.1. хоёроос доошгүй судалгааны төсөл (ШУТС, МУИС-ийн захирлын 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/52 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журам"-д заасан болон гадаад санхүүжилттэй төсөл) хэрэгжүүлсэн байх;

2.3.2. удирдсан төслийн санхүүжилтээс МУИС-д шууд бус зардлын шимтгэл төлснийг баримтжуулах;

2.3.3. Web of Science-ийн JCR индекстэй мэргэжлийн сэтгүүлд гурваас доошгүй өгүүлэл эсвэл олон улсад SPI, SENSE-ийн индекстэй академик пресст хэвлүүлсэн нэг сэдэвт зохиол нэгээс доошгүй байх;

2.3.4. тухайн судалгааны лабораторийн дэд бүтэц, орчин бүрдсэн байдлыг баримтжуулж нотлох.

2.3.5. багт нь хүний нөөцийн бүрдсэн байдал (судалгааны туслах, эрдэм шинжилгээний ажилтан, докторын дараах судлаач, магистрант, докторантын тоо)-ыг нотлох.

## ГУРАВ. ЛАБОРАТОРИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Лаборатори үйл ажиллагааны тайланг тухайн хичээлийн жилийн хоёрдугаар улирлын төгсгөлд ЭШММС-д бүртгүүлнэ.

3.2. Лабораторийн үйл ажиллагааны үнэлгээг 3 жил тутам ЭШИХ зохион байгуулна.

3.3. Лабораторийн ерөнхий үнэлгээг гаргахдаа энэ журмын хавсралтаар заасан гол шалгуур үзүүлэлт (хавсралт)-ийн нийлбэр оноогоор дүгнэнэ. Үүнд:

Оноо	Ерөнхий үнэлгээ
A ≥80	Тогтвортой
60 ≤B <80	Хангалттай
C<60	Хангалтгүй

1117144746  
УХД0072 9104399

3.4. Лабораторийн ерөнхий үнэлгээ нь цаашид тухайн лабораторийг дэмжих, чиглэл солих, үйл ажиллагаагаа сайжруулах хугацаатай даалгавар өгөх эсвэл татан буулгах санал оруулах үндэслэл болно.

#### ДӨРӨВ. ЛАБОРАТОРИЙН УДИРДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

##### 4.1. Лабораторийн удирдагч дараах эрхтэй.

4.1.1. судалгааны төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг гэрээний дагуу зарцуулах;

4.1.1. гадаадад удаан хугацаагаар явах, тэтгэвэрт гарах, өөр ажилд шилжихэд саналыг нь үндэслэн шинэ томилгоог ЭШИХ-ээр уламжлуулан МУИС-ийн захирлын тушаалаар шийдвэрийг баталгаажуулах.

##### 4.2. Лабораторийн удирдагч дараах үүрэгтэй.

4.2.1. лабораторийн үйл ажиллагааны хүрээнд гарсан эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт зохиол, програм хангамж, өгөгдөл зэрэгт оюуны өмчийн эрхийг хамгаалах;

4.2.2. Сайн лабораторийн зарчим (GLP)-д үндэслэн лабораторийн ерөнхий дотоод дүрэм, лабораторийн аюулгүй ажиллагаа, судалгааны тоног төхөөрөмжийг ашиглах журмуудыг боловсруулж батлуулах;

4.2.3. тоног төхөөрөмжийн аюулгүй, өндөр үр өгөөжтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах, шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодис, материалын хөрөнгө оруулалтыг хангах;

4.2.4. улсын стратегийн ач холбогдол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлын нууцлалыг чанд сахиж холбогдох журмыг мөрдөх;

4.2.5. нээлттэй судалгааны зарчмаар гадаад, дотоодын өндөр түвшний судлаачдыг татан оролцуулж, лабораторийн хамтарсан судалгааг хангах


#### ТАВ. ЛАБОРАТОРИЙГ ТАТАН БУУЛГАХ

5.1. Лабораторийг татан буулгах, харьяалал өөрчлөх, нэрийг солих ажлыг тус лабораторийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн байгуулсан профессор багшийн саналыг харгалзаж, салбарын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн гарсан дүгнэлтийг ЭШИХ хянаж, МУИС-ийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

5.2. Лаборатори цаашид үйл ажиллагаагаа санхүүжүүлэх бололцоогүй хэмээн лабораторийн удирдагч үзэж лабораторийг татан буулгах саналаа ЭШИХ-ээр хянуулан ирүүлсэн нөхцөлд МУИС-ийн захирлын шийдвэрээр лаборатори өөрөө татан буугдсанд тооцно.


5.3. Лаборатори татан буугдсан нөхцөлд тус лабораторийн үндсэн хөрөнгийг харьяалагдах бүрэлдэхүүн сургуульд шилжүүлнэ.

5.4. Лаборатори татан буугдахад хүний нөөцийг "Монгол Улсын хөдөлмөрийн хууль"-д нийцүүлэн шийдвэрлэнэ.





Хавсралт . Судалгааны лабораторийн үнэлгээний шалгуур үзүүлэлт.

Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Оноо		Үзүүлэлтийн агуулга
1. Судалгааны гүйцэтгэл (60)	1.1. Web of Science санд бүртгэлтэй SSCI, SCI, A&HCI индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл	Нэгдүгээр буюу холбоо барих зохиогч	30	 Судалгааны гүйцэтгэл
		Бусад зохиогч	10	
	1.2. Олон улсад хэвлүүлсэн нэг сэдэвт зохиол (SPI, SENSE-ийн индекстэй академик пресст хэвлүүлсэн)	Нэгдүгээр зохиогч буюу холбоо барих зохиогч	30	
		Бусад зохиогч	10	
	1.3. Оюуны өмчийн хөрөнгө	Идэвхитэй патентын тоо (Гадаад, дотоод)	20	
		Идэвхигүй патентын тоо	10	
		Патентын мэдүүлэг (Гадаад, дотоод)	10	
Ашигтай загвар Бүтээгдэхүүний загвар		10		
2. Дансаар орж ирсэн төслийн санхүүжилт (30)	2.1. Санхүүжилт нь МУИС-ийн дансаар орж төслийн мөнгөн дүн (сая төгрөг)	10-50 сая төгрөг	6	Гадаад, дотоод судалгааны төсөл, гэрээт, захиалгат ажил
		50-150 сая төгрөг	12	
		150-250 сая төгрөг	18	
		250-350 сая төгрөг	24	
		350-с дээш сая төгрөг	30	
3. GLP Сайн лабораторийн зарчмын биелэлт (10)	3.1. GLP Сайн лабораторийн зарчимд үндэслэн ерөнхий дотоод журмыг хэрэгжүүлэх, лабораториуд өөрийн үнэлгээнд ашигладаг байх	10	GLP Сайн лабораторийн зарчимд үндэслэн ерөнхий дотоод журамтай байна. Боловсруулсан ерөнхий журмын дагуу лабораториуд өөрийн үнэлгээнд ашиглаж үндэсний жишиг болгоно. "GLP Сайн лабораторийн зарчим" сэдэвт сургалтыг судлаачдад зориулж зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.	
	3.2. "GLP Сайн лабораторийн зарчим" сургалтанд хамрагдсан оролцогчдын гарын үсэгтэй баримт нотолгоо	10		